



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/116

Мөрөн сум

Автотээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын үзлэгийг сумдад зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг зохион байгуулсугай.

2. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумдад тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг тооллого явуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

3. Сум, багт байгаа автомашин, чиргүүл, трактор өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн бүртгэл судалгааг гаргах, техникийн үзлэгт тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах ажлуудыг зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Автотээврийн хэрэгслийн явуулын техникийн хяналтын үзлэгийн үеэр тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг хийх, мотоциклд улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, бүртгэлийг хийх, ашиглахаа больсон боловч улсын бүртгэлийн санд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллахыг Автотээврийн төвийн дарга (Ө.Баттулга)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 11.7 ны өдрийн  
А/11.6 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



Комиссын дарга:

М Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд :

Ө.Баттулга	(Аймгийн Автотээврийн төвийн дарга)
Т.Ганхуяг	(Аймгийн Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
Ч.Хуншагай	(Аймгийн Татварын хэлтсийн дарга)
Б.Батбаяр	(Мөрөн сумын Засаг дарга)
Д.Ууганбаяр	(Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа)
Б.Оюунтуяа	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Х.Бямбадорж (Аймгийн Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер)

\_\_\_оОо\_\_\_

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 17-ны өдрийн  
А/166... дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт

СУМДАД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ  
ТООЛЛОГО ЯВУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Нэгдүгээр чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Ажиллах хоног
1	Тосонцэнгэл	Автотээврийн төвийн ажлын хэсэг	4/18-19	2 хоног
2	Рашаант		4/20-21	2 хоног
3	Их-Уул		4/22-23	2 хоног
4	Тариалан		4/24-26	3 хоног
5	Эрдэнэбулган		4/27-28	2 хоног
6	Чандмань-Өндөр		4/30-5/1	2 хоног
7	Цагаан-Үүр		5/2-3	2 хоног
8	Түнэл		5/4-5	2 хоног
нийт				18 хоног
Д/д	Хоёрдугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Ажиллах хоног
1	Төмөрбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг	5/9-10	2 хоног
	Шинэ -Идэр		5/11-12	2 хоног
2	Галт		5/13-14	2 хоног
3	Жаргалант		5/15-17	3 хоног
5	Цэцэрлэг		5/19-20	2 хоног
6	Цагаан -Уул		5/21-23	3 хоног
7	Бүрэнтогтох		5/24-25	2 хоног
нийт				17 хоног
Д/д	Гуравдугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Ажиллах хоног
1	Арбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг	6/2-3	2 хоног
2	Баянзүрх		6/4-5	2 хоног
3	Улаан-Уул		6/6-7	2 хоног
4	Ренчинлхүмбэ		6/8-9	2 хоног
5	Цагааннуур		6/10-11	2 хоног
6	Хатгал		6/12-13	2 хоног
7	Алаг-Эрдэнэ		6/14-15	2 хоног
нийт				14 хоног
Д/д	Дөрөвдүгээр чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Ажиллах хоног
1	Ханх	Автотээврийн төвийн ажлын хэсэг	6/22-25	4 хоног
нийт				4 хоног